

Дэгд (*Gentiana* L.)-ийн төрлийн ургамлын уламжлалт мэдлэг, хэрэглээг судалсан үр дүн

Вэн Чао (Wen Chao)^{1,4}, Ц.Батцэрэн², Г.Батзаяа^{2,3}, Алмаз Боржигдай (Almaz Borjigidai)⁴, Б.Цэрэнцоо¹

¹АШУУИС, МАУОУС, Уламжлалт жор судлалын тэнхим

²ШУА, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн

³Монголын Шинжлэх Ухааны Академийн Их Сургууль

⁴Хятадын Төвийн Үндэстний (Минзү) Их Сургууль, Угсаатан судлалын тэнхим
Цахим шуудан: bid24e011@gt.mn.ums.edu.mn, Утас: +976-99242596

Түлхүүр үг:

Этноботаник
Нутгийн нэршил
Цагаан таш
Хөх дэгд
Чонын хэл
Зүлгэнчимэг

Товч утга:

Үндэслэл: Угсаатны анагаах ухаанд эмийн ургамлын уламжлалт мэдлэг, хэрэглээний судалгаа нь судлаачдад ургамлын хэрэглээг төрөл бүрийн аргаар судлах боломжийг нээж, ургамлын гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед чухал ач холбогдолтой юм. Иймээс бид Монгол болон ӨМӨЗО-ны зарим аймгуудад хийсэн Дэгд төрлийн ургамлын уламжлалт мэдлэг, хэрэглээг судаллаа. **Зорилго:** Газарзүйн ялгаатай бүс нутгийн ард иргэдийн Дэгд төрлийн ургамлын эмийн түүхий эдийн уламжлалт хэрэглээг судлахын зэрэгцээ ургамлын адилцаа нэр буюу нутгийн нэршлийг илрүүлэх. **Арга, аргачлал:** Монгол болон ӨМӨЗО-ны зарим нутагт нийт 190 соёлын өв тээгчээс 36 асуумж бүхий этноботаникийн судалгааг авсан. Асуумж судалгааны мэдээллийг боловсруулан Дэгд төрлийн ургамал тухайн бүс нутагт хир чухал эсэхийг ашиглалтын индекс болон харьцангуй давтамжийн индексээр тодорхойлов. **Үр дүн:** Дэгд төрлөөс *Gentiana algida*, *G. macrophylla*, *G. decumbens*, *Gentianopsis barbata* гэх 4 зүйлийн ургамлыг 2 улсын өв тээгчид нэрлэсэн бөгөөд тухайн бүс нутаг дахь ургамлын гаралтай түүхий эдийн чухал эсэхийг тодорхойлдог харьцангуй давтамжийн индексийн дүнгээр судалгаа явуулсан Монгол Улсын нутагт Том навчит дэгд - 0,37, Хэвтээ дэгд - 0,51, Цагаан дэгд - 0,55 байгаа нь эдгээр ургамлын түүхий эдийг бүс нутагт өргөн ашигладаг, чухал хэрэгцээтэй болохыг илтгэж байна. Харин ӨМӨЗО-ны судалгаа явуулсан нутагт харьцангуй давтамжийн индекс Цагаан дэгд 0,08, Том навчит дэгд 0,18, Хэвтээ дэгд 0,21 байгаа нь бүс нутагт Дэгд төрлийн ургамлын түүхий эд бага ашиглагддаг болохыг харуулж байна. Гэвч энэ нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхэлж буйтай холбоотой байх талтай юм. **Дүгнэлт:** 1. Дэгд төрлийн ургамлын түүхий эдийн хэрэглээ бүс нутагт ялгаатай байна. 2. Дэгд төрлийн ургамлыг хоёр орны өв тээгчид цэцгийн өнгө, овор хэмжээ, нутгийн аялгаар ялгаатай нэрлэж ирсэн болохыг судлан тогтоолоо.

Үндэслэл: Хятад, Монгол хоёр улс нь уламжлалт анагаах ухааны олон зуун жилийн турш хуримтлагдсан мэдлэг, туршлагатай ургамлын гаралтай эмт бодис, эмийн хэрэглээ өндөртэй орнууд болох нь цөөнгүй судалгаанд дурдагдсан байна.

Дэлхийд Дэгдийн овгийн 83 төрөлд хамаарах 1050 орчим зүйл өвслөг олон наст ургамал сэрүүн болон хүйтэн бүсийн нутгаар тархжээ.¹ Монгол оронд 9 төрлийн 32 зүйл ургамал ургадаг болохыг тэмдэглэсэн байдаг.^{2,3} *Gentianaceae* Juss. овгийн 4

төрөл 12 зүйл ургамлын тоосны хэлбэрзүйн судалгааг нарийвчлан хийсэн байна. Өдгөө Монгол оронд 108 овогт хамаарах 684 төрлийн 3160 зүйл гуурст ургамал бүртгэгдсэнээс нэн ховор 133 зүйл, ховор 356 зүйл ургамал байгааг тогтоосон байдаг.^{6,7} Монгол орны ургамлын аймагт 22 зүйл Дэгд бүртгэгдсэнээс 12 зүйл ургамлыг уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг ба тэдгээрээс 2 зүйл нэн ховор (*Gentiana macrophylla*, *G. pulmonaria*), 3 зүйл ховор (*Gentiana algida*, *G. barbata*, *G. riparia*) ургамлын жагсаалтад ордог.⁸ Уг

овгийн төлөөлөгчдөд гетеростиль, дихогами үзэгдэл ажиглагдахаас гадна иридоид, гликозид, флавоноид, ксантин, фенолийн хүчил, алкалоид, генциопикрин хэмээх глюкозид илэрдэг учир эмийн төдийгүй хүнс тэжээлийн чухал ач холбогдолтой.⁹ Gentianaceae Juss. овгийн 4 төрөл 12 зүйл ургамлын тоосны хэлбэрзүйн судалгааг нарийвчлан хийсэн байна. Дэгд төрлийн зарим зүйл ургамлын эм, танд оруулан хэрэглэж ирсэн бөгөөд амьсгалын замын өвчний үед хэрэглэгддэг жорд цагаан дэгдийг, халуун бууруулах өвчин намдаах үйлчилгээтэй жорд том навчит дэгдийг, савын халуун, нян халуун дэлгэрсэн, тулай, хэрх, шар усны өвчин, үе мөчөөр хавдах, хулгана яр, хорын халуун дэлгэрсэн, боом өвчин эмнэхэд, элэг цөсний өвчинд хэрэглэгддэг жорд хэвтээ дэгдийг хэрэглэж ирсэн байна.¹¹⁻¹³ Тиймээс бид Хятад болон Монгол орны тэгш өндөрлөгт ургадаг Дэгд (*Gentiana* L.)-ийн төрлийн ургамлын уламжлалт хэрэглээг судлан баримтжуулж тэдгээрийн эрүүл мэндэд үзүүлэх ашиг тус, практик хэрэглээ бүс нутагт ямар ялгаатай байгааг илрүүлэх нь энэхүү судалгааны ажлын үндэслэл боллоо.

Зорилго: Газарзүйн ялгаатай бүс нутагт Дэгд (*Gentiana* L.)-ийн төрлийн ургамлын уламжлалт хэрэглээг судлах

Зорилт:

1. Хятад, Монгол 2 улсын ард иргэдийн Дэгд төрлийн ургамлын эмийн түүхий эдийн уламжлалт хэрэглээ, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг этноботаникийн үзүүлэлтээр судлах
2. Дэгд төрлийн ургамлын адилцаа нэр буюу ардын нэршлийг судлан илрүүлэх

Арга, аргачлал: Бид уг судалгааг АШУҮИС-ийн МАУОУС, МУАУ-ны хүрээлэн, Шинжлэх Ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ургамалжлын экологи, ургамлын эдийн засгийн лаборатори, Монголын Шинжлэх Ухааны Академийн Их Сургууль, Хятадын Төвийн Үндэстний (Минзү) Их Сургууль Угсаатан судлалын тэнхимийг түшиглэн хийлээ. Бид судалгаандаа уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг Дэгд (*Gentianaceae* Juss.)-ийн овгийн Том навчит дэгд (*Gentiana macrophylla* Pall.) Өлчир дэгд (*Gentiana algida* Pall.), Хэвтээ дэгд (*Gentiana decumbens* L.F) Сормууст дэгдхэй (*Gentianopsis barbata* (Froel.) Ma гэсэн эмийн ашигтай 4 зүйл ургамлыг сонгосон (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан ургамлын төрөл, зүйл, статусын байдал

Зүйлийн нэр	Статус	Ургамлын эрхтний хэсэг
<i>Gentiana macrophylla</i> Pall	нэн ховор	газрын дээд хэсэг
<i>Gentiana algida</i> Pall.	ховор	газрын дээд хэсэг
<i>Gentianopsis barbata</i> (Froel.) Ma.	ховор	газрын дээд хэсэг
<i>Gentiana decumbens</i> L.	элбэг	газар дээд хэсэг

Монгол, Хятад улсын нутагт насны бүлэг харгалзахгүйгээр ард иргэдийг хамруулан асуумж судалгаа авч ярилцлага хийсэн.¹⁴ Ингэхдээ ургамлын уламжлалт мэдлэгийн судалгаанд бичгийн анкетын арга буюу нэгдсэн нэг хэв загварын асуулт тавьж, ярилцагч асуултад байж болох өгөгдсөн хариултаудаас сонголт хийн, нэмэн дэлгэрүүлж хариулах замаар ярилцлагын хэлбэрээр судалгааг явуулан ургамлын нэр, нэршил, ургах орчин, хэрэглээний талаарх мэдээ, баримтыг цуглуулан зураг авч баримтжуулав. Цуглуулсан мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан буюу дата бааз үүсгэлээ.^{15,16}

Дэгд төрлийн ургамлын түүхий эдийн уламжлалт хэрэглээг Монгол улсын Архангай, Хэнтий, Хөвсгөл аймгийн 129 иргэн болон Хятад улсын ӨМӨЗО-ны Бугат хот, Хөх Хот, Ордос хот, Хөлөнбуйр хот, Тонляо хот, Улаан хад хот, Улаанцав хот, Хянган болон Шилийн гол аймгийн 61 иргэн, нийт 190 соёлын өв тээгчээс 36 асуумж бүхий этноботаникийн судалгааг авсан. Асуумж судалгааны мэдээллийг боловсруулан Дэгд төрлийн ургамал тухайн бүс нутагт хир чухал эсэхийг харьцангуй давтамжийн индекс (Relative frequency citation, RFC) болон ашиглалтын индекс (Use value, UV)-г 2 орны бүс нутагт хамаарах мэдээлэгч болон ургамлыг ашиглан тодорхойлов.

Үр дүн: Дэгд төрлөөс *Gentiana algida*, *G. macrophylla*, *G. decumbens*, *G. barbata* зэрэг 4 зүйл ургамлын уламжлалт мэдлэгийн талаар Монгол улсын өв тээгчид мэдээлсэн бол ӨМӨЗО-ны Бугат, Ордос, Улаан хад, Улаанцав хотын иргэд Дэгд төрлийн ургамлын талаар мэдэхгүй гэдгээ илэрхийлж, Хөлөнбуйр, Хөх хот, Тонляо, Шилийн гол, Хянган аймгийн өв тээгчид өөрсдийн мэдэх уламжлалт мэдлэгээ хуваалцсан. Ашиглалтын индекс болон харьцангуй давтамжийн индексийн дүнгээс харахад Дэгд төрлийн ургамлаас Хэвтээ дэгд, Цагаан дэгд, Том навчит дэгд зэрэг 3 зүйл ургамлыг Монгол орны Архангай, Хэнтий, Хөвсгөл аймгийн иргэд нэлээд түгээмэл ашигладаг байна. Харин ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хөх хот, Тонляо, Шилийн гол, Хянган аймагт мөн эдгээр 3 зүйл ургамлыг харьцангуй цөөн өв соёл тээгчид мэдээлсэн ба ашиглалт болон харьцангуй давтамжийн индекс бага дүнтэй гарсан байна (хүснэгт 2). Судалгаа хийх явцад байгалийн ургамлыг мэдэх иргэд цөөн байгаа нь ажиглагдаж байсан ба энэ нь тус бүс нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хөгжсөнтэй холбоотой байх магадлалтай байна (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Дэгд төрлийн ургамлын нэршил, харьцангуй давтамжийн индекс (Relative frequency citation, RFC) болон ашиглалтын индекс (Use value, UV)

Ургамлын гаралтай түүхий эд	Адилцаа нэр (Нутгийн нэршил)	N	Ui	UV	FC	RFC (0<RFC<1)
Монгол улс /Архангай, Хэнтий, Хөвсгөл аймаг/						
Цагаан дэгд	Шар дэгд / Цагаан таш	129	79	0,61	71	0,55
Том навчит дэгд	Хүрэн дэгд, Үхэр дэгд, Чонын хэл	129	69	0,53	48	0,37
Хэвтээ дэгд	Хөх дэгд, Хөх таш	129	88	0,68	66	0,51
Сормууст дэгдхэй	Зэс дэгд	129	18	0,14	8	0,06
ӨМӨЗО /Хөлөнбуйр, Хөх хот, Тонляо, Шилийн гол, Хянган/						
Цагаан дэгд	Цагаан төмөр дэгд, Цагаан зүлгэнчимэг, Цагаан банжин	61	9	0.14	5	0.08
Том навчит дэгд	Өв дэгд, Том зүлгэнчимэг, Хар жилж	61	15	0.24	11	0.18
Хэвтээ дэгд	Хар төмөр дэгд, Дэгэнцэр, Дэгдээ иш	61	16	0.26	13	0.21

Тайлбар: И- Тухайн бүсийн нийт өв соёл тээгч, Ui – Тухайн ургамлын түүхий эдийг хэдэн удаа дурдсан тоо, UV – Ашиглалтын индекс, FC – Тухайн зүйл ургамлыг дурдсан өв соёл тээгчийн тоо, RFC – Харьцангуй давтамжийн индекс

Дэгд төрлийн ургамлыг адилцаа нэр буюу нутгийн нэршлээр монголчууд Цагаан дэгдийг Шар дэгд; Том навчит дэгдийг Хүрэн дэгд, Үхэр дэгд; Хэвтээ дэгдийг Хөх дэгд гэх ба Хөвсгөл аймгийн дархад ястнууд Цагаан дэгдийг Цагаан таш, Хөх дэгдийг Хөх таш, Том навчит дэгдийг Чонын хэл, Сормууст дэгдхэйг Зэс дэгд гэж нэрлэдэг бол Өвөрмонголчууд Цагаан дэгдийг Цагаан төмөр дэгд, Цагаан зүлгэнчимэг, Цагаан банжин; Том навчит дэгдийг Өв дэгд, Том зүлгэнчимэг, Хар жилж, Хэвтээ дэгд Хар төмөр дэгд, Дэгэнцэр, Дэгдээ иш гэх зэргээр нэрлэдэг байна.


Ургамлын адилцаа нэрийн үүсэл болон нэршлийг нэгдсэн байдлаар судалснаар ургамал хэрэглэгчдэд үнэн зөв мэдээллийг түгээх, зохистой хэрэглээг бий болгох ач холбогдолтой. Судалгаа явуулсан Монголын аймгуудад дараах Дэгд төрлийн ургамлын түүхий эдийг ханиад, халуун бууруулах, элэг цөс, үе мөчний өвчинд монголын Архангай, Хэнтий аймгийнхан нийтээрээ хэрэглэдэг бол Хөвсгөл аймагт Том навчит дэгдийг бөөр, ходоод, хавдар, ил шархыг анагаах чиглэлээр өргөн хэрэглэж байгаа нь бусад 2 аймгаас ялгаатай үр дүн байв (Зураг 1).



Зураг 1. Монголд Улсад Дэгд төрлийн 3 зүйл ургамлын уламжлалт хэрэглээг судалсан дүн

Харин Өвөрмонголд судалгаа явуулсан аймаг, хотуудад Дэгдийн төрлийн ургамлыг Хөлөнбуйр, Хөх хот, Тонляо, Шилийн гол, Хянган аймгийн өв тээгчид

халуун бууруулах, элэг цөсний өвчин, өвдөлт намдаахад голчлон хэрэглэхийн зэрэгцээ тулай, үе мөчний өвчин, хоолой болон хор тайлахад хэрэглэдэг байна (Зураг 2)



Зураг 2. ӨМӨЗО-д Дэгд төрлийн 3 зүйл ургамлын уламжлалт хэрэглээг судалсан дүн

Дэгд төрлийн зарим зүйл ургамлын эм, тангийн судалгаагаар амьсгалын замын өвчний үед хэрэглэгддэг жор: Цагаан дэгд-*Gentiana algida* Pall. - Төвд нэр: (банжангарбо) Адилцаа нэр: Шар дигд, өлчир дигд, банжингарав Эмийн түүхий эд: Газрын дээрх хэсэг Арви: Их Амт чадал: Амт нь гашуун. Чадал нь сэрүүн, шингэн. зөөлөн Үйлдэл үйлчилгээ: Хоолой, уушги, нүдэнд нян халуун дэлгэрсэн, дуу сөөнгөтөх, цэр элбэгших, амьсгаадах, хорын халуун, хижиг халуунд туслана. Жор: Банжингарав-15, Лиш-6, Арүр-12, Банжин-12, Врайвү-6, Гарбо-6, Сантал 25, Яжима-18, Зову-25, Бонтаг-25, Цулхир-4 Халуун бууруулах өвчин намдаах үйлчилгээтэй жор: Том навчит дэгд-*Gentiana macrophylla* Pall. Төвд нэр: (жилж) Адилцаа нэр: Хүрэн дигд, дигд, үхэр дэгд Эмийн түүхий эд: Газрын дээрх хэсэг Арви: Бага Амт чадал: Амт нь гашуун. Чадал нь сэрүүн, ширүүн. Үйлдэл үйлчилгээ: Халуун бууруулж өвчин намдаана. Цөс хөөхийн хамт гистамин төст

үйлдэлтэйг эмзүйн судалгаагаар тогтоосон. Жор: Арүр-3, Хонлин-6 Бусад ач холбогдол: Савын халуун, нян халуун дэлгэрсэн, тулай, хэрх, шар усны өвчин, үе мөчөөр хавдах, хулгана яр, хорын халуун дэлгэрсэн, боом өвчин эмнэхэд тустай. Элэг цөсний өвчинд хэрэглэгддэг жор: Хэвтээ дэгд - *Gentiana decumbens* L. Төвд нэр: Одева Адилцаа нэр: Үхэр дигд, хөх дигд, төмөр дигд Эмийн түүхий эд: Цэцэг Арви: Бага Амт чадал: Амт нь гашуун, амтлаг. Чадал нь сэрүүн, ширүүн. Үйлдэл үйлчилгээ: Халуун намдаана, ходоод, цөсний үрэвслийг намдаана. Төвд эмнэлэгт газрын дээрх хэсгийг ходоодны архаг үрэвсэл, цөсний хүүдийн үрэвсэл, мэдрэлийн ядаргааны үед, цэцгийг халдварт өвчний үед хэрэглэдэг. Жор: Бонгар-12, Врагшун-7, Гагол-18, Дүдзисэлжор, Жабур-8 Бусад ач холбогдол: Хижиг халуун, нян халуун, хор тайлах, шарын халуунд тусална (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Дорнын уламжлалт анагаах ухаанд Дэгд төрлийн ургамлын хэрэглээ, судлагдсан байдал

Монгол нэр	Амт чадал	Үйлдэл үйлчилгээ	Монгол уламжлалт эмнэлэгт	Төвд эмнэлэгт	Жоруудын тоо ба найрлагад орох давтамж
Цагаан дэгд (Өлчир дэгд, Шар дэгд, Банжингарав)	Амт нь гашуун Чадал нь сэрүүн, шингэн, зөөлөн	Хоолой, уушги, нүдэнд нян халуун дэлгэрсэн, дуу сөөнгөтөх, цэр элбэгших, амьсгаадах хорын халуун, хижиг халуун бууруулах	Амьсгалын замын өвчний үед ханиалга дарах, дуу хоолой сөөнгөтөх, уушгинд цэр элбэгших, амьсгаадах бүх төрлийн хордлого тайлах	Хоолой, төвөнхийн үрэвсэл анагаах, халдварт өвчний үед халуун бууруулах, ходоодны хүчиллэг багассан үрэвслийн үед	Монгол-төвд ухааны эмнэлгийн эмийн 76 жорд, жорын найрлагад орох давтамжаар 78-рт, монгол орны эмийн найрлагад орох давтамжаар 26-рт жагссан.
Том навчит дэгд	Амт нь гашуун Чадал нь сэрүүн, ширүүн.	Халуун бууруулах, өвчин намдаах, цөс хөөх	Халуун бууруулах, өвчин намдаах, цагаан мөгөөрсөн хоолой, төвөнхийн үрэвсэлд, цөс хөөх	Халууныг хариулах, хавдар сахуу, шар усыг дарах, хаван хөөх, үе мөчний хавдар, шар усыг хатаах, арьсны өвчинд	Монгол-төвд ухааны эмнэлгийн эмийн 86 жорд, жорын найрлагад орох давтамжаар 72-рт, монгол орны эмийн найрлагад орох давтамжаар 23-рт жагссан.
Хэвтээ дэгд	Амт нь гашуун, амтлаг. Чадал нь сэрүүн, ширүүн.	Хижиг халуун, нян халуун, хор тайлах, ходоод, элэг цөсний үрэвслийг намдаах,	Элэг цөсний өвчинд, халдварт өвчний үед халуун бууруулах	Ходоодны архаг үрэвсэл, цөсний хүүдийн үрэвсэл, мэдрэлийн ядаргаа, халдварт өвчний үед	Монгол орны эмийн найрлагад орох давтамжаар 25 -рт жагссан.
Сормууст дэгдэнцэр	Амт нь гашуун, амтлаг. Чадал нь сэрүүн, ширүүн	Хижгийн ба шарын халуун, шархны халууныг дарах	Элэгний эд, эсийн үйл ажиллагааг сайжруулах, элэгний хордлогоос сэргийлэх, хордлого тайлах	Шарын халуун, арьс, нүд шарлахыг арилгах, шарх анагаах	Монгол-төвд ухааны эмнэлгийн эмийн 263 жорд, жорын найрлагад орох давтамжаар 20-рт, монгол орны эмийн найрлагад орох давтамжаар 4-рт жагссан.

Дэгд ургамлын түүхий эдийг өргөн ашигладаг бөгөөд *Gentiana algida*, *G.macrophylla*, *G.decumbens* 3 зүйлийн ургамлыг ханиад амьсгалын замын өвчин, халуун бууруулах, элэг цөс, үе мөчний өвчнийг анагаахад нийтээрээ хэрэглэдэг. Мөн ходоод, бөөр, хавдар, шарх сорви анагаахад хэрэглэж байгааг тогтоов. Цагаан дэгд-*Gentiana algida* -ыг амьсгалын замын өвчний үед хэрэглэгддэг жор найрлагад, Хэвтээ дэгд - *Gentiana decumbens* L-ийг элэг цөсний өвчинд хэрэглэгддэг жор найрлагад, Том навчит дэгд-*Gentiana macrophylla* Pall-ийг халуун бууруулах өвчин намдаах үйлчилгээтэй жор найрлагад түлхүү хэрэглэж байна.

Хэлцэмж: Хүний эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх зарчим өрнө болоод дорны анагаах ухаанд аль алинд оршин байдаг хэдий ч тэдгээрийн тайлбарлах зарчим, онол, философи нь харилцан адилгүй байдгаараа ялгаатай юм. Гэсэн хэдий ч ардын эмчилгээнээс улбаат эмчилгээний олон арван арга, domuуд өдгөөг хүртэл хэрэглэгдэж байгаа хэдий ч цөөхөн хүрээнд ашиглагдаж байна. Орчин үед дэлхий нийтээрээ эмгүй эмчилгээний олон арван аргуудыг орчин үеийн анагаах ухаантай хослуулах, мартагдах дөхсөн дом засал аргуудыг дахин сэргээх, тэдгээрийг орчин үеийн технологи ашиглан шинэ хэлбэрт оруулж

эмчилгээнд ашиглах байдал түлхүү ажиглагдах болсон нь сайшаалтай байгаа юм. Тухайлбал: шамбрам өвчин бол орчин үеийн анагаах ухааны ойлголтоор мэс заслын өвчин байдаг бол ардын эмчилгээ, УАУ-нд үүнийг мэсийн бус өвчний бүлэгт хамааруулан авч үздэг. Шамбрам өвчнөөр хагалгаа хийлгэсэн өвчтөн хагалгааны дараах эдгэрэлтийг түргэсгэх эмчилгээний давуу чанарууд нь уламжлалт, ардын эмчилгээ тал руугаа түлхүү байх зэрэг ажиглагдаж байна. Тийм учраас анагаах ухааны салбаруудыг тусад нь ойлгох бус хооронд нь уялдуулан авч үзэх чухал байгааг эмнэлзүйн практик харуулсаар байна.

Бидний судалгаагаар Дэгд төрлөөс *Gentiana algida*, *G.macrophylla*, *G.decumbens*, *Gentianopsis barbata* гэх 4 зүйлийн ургамлыг 2 улсын өв тээгчид нэрлэсэн бөгөөд тухайн бүс нутаг дахь ургамлын гаралтай түүхий эдийн чухал эсэхийг тодорхойлдог харьцангуй давтамжийн индексийн дүнгээр судалгаа явуулсан Монгол Улсын нутагт Том навчит дэгд - 0,37, Хэвтээ дэгд - 0,51, Цагаан дэгд - 0,55 байгаа нь эдгээр ургамлын түүхий эдийг бүс нутагт өргөн ашигладаг, чухал хэрэгцээтэй болохыг илтгэж байна. Дэгд төрлийн ургамлыг адилцаа нэр буюу нутгийн нэршлээр монголчууд Цагаан дэгдийг Шар дэгд; Том навчит дэгдийг Хүрэн дэгд, Үхэр дэгд; Хэвтээ дэгдийг Хөх

дэгд гэх ба Хөвсгөл аймгийн дархад ястнууд Цагаан дэгдийг Цагаан таш, Хөх дэгдийг Хөх таш, Том навчит дэгдийг Чонын хэл, Сормууст дэгдхэйг Зэс дэгд гэж нэрлэдэг бол Өвөрмонголчууд Цагаан дэгдийг Цагаан төмөр дэгд, Цагаан зүлгэнчимэг, Цагаан банжин; Том навчит дэгдийг Өв дэгд, Том зүлгэнчимэг, Хар жилж, Хэвтээ дэгд Хар төмөр дэгд, Дэгэнцэр, Дэгдээ иш гэх зэргээр нэрлэдэг байна. Ургамлын адилцаа нэрийн үүсэл болон нэршлийг нэгдсэн байдлаар судалснаар ургамал хэрэглэгчдэд үнэн зөв мэдээллийг түгээх, зохистой хэрэглээг бий болгох ач холбогдолтой юм. Судалгаа явуулсан аймгуудад Дэгд төрлийн ургамлын түүхий эдийг ханиад, халуун бууруулах, элэг цөс, үе мөчний өвчинд Архангай, Хэнтий аймгийнхан нийтээрээ хэрэглэдэг бол Хөвсгөл аймагт Том навчит дэгдийг бөөр, ходоод, хавдар, ил шархыг анагаах зорилгоор хэрэглэж ирсэн байна.

Дүгнэлт:

1. Дэгд төрлийн ургамлыг Монгол Улсад Хөвсгөл аймгийн иргэд түгээмэл хэрэглэж байна.
2. Хоёр орны иргэд Дэгд төрлийн ургамлыг цэцгийн өнгө, овор хэмжээ, нутгийн аялгаар ялгаатай нэрлэн, хэрэглэдэг болохыг тогтоолоо.

Ном зүй:

1. Володя Ц., Цэрэнбалжир Д., Ламжав Ц. 2008. Монгол орны эмийн ургамал. УБ.
2. Грубов В.И. 2008. Монголын суурст ургамал таних бичиг. Ган принт. УБ.
3. Губанов И.А. 1996. Конспект флоры Внешней Монголии. М:

Баланг.

4. Жамъяндорж Х., Лигаа У., Отгонбилэг Х., Саарал Н. 2011. Хэрлэний хөдөө аралд тарьсан нэн ховор, ховор, ашигт ургамал. УБ.
5. Лигаа У. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. Бемби сан. 2015. 163-164.
6. Монгол улсын Засгийн газрын Байгалийн ургамлын тухай хуулийн 1995 оны 153 дугаар тогтоолын хавсралт. Ховор ургамлын жагсаалт
7. Монгол улсын Засгийн газрын 2004 оны 165-р тогтоолоор нэмэгдсэн Ховор ургамлын жагсаалт
8. Мөнхжаргал Б., Лигаа У., Очирбат Г., Батцэрэн Ц. Монгол орны ашигт ургамлын тархац, нөөцийн атлас. УБ. 2014. 116.
9. Uragamal M., Oyuntsetseg B., Nyambayat D., Dulamsuren Ch. Conspectus of the vascular plants of Mongolia. UB, Mongolia. "Admon Printing" Press. 2014. 334pp
10. ШУА, Түүхийн хүрээлэн. "БНМАУ-ын Угсаатны зүй-1". УБ.1987 он
11. Чагданхорлоо Х. Эмийн түүхий эд судлалд монголчуудын оруулсан хувь нэмрийг харьцуулан судалсан зарим үр дүн: АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2016.
12. Авирмэд С. Гүн Гомбожавын "Эмийн нэрилийн төвөд, хятад хэлний хадмал оршвой" зохиолын харьцуулсан судалгаа: АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2014.
13. Б. Отгончимэг, Ю. Галмандах, Х. Солонго ба бусад. Уламжлалт анагаах ухааны тооны нэрийн бэлгэдэл зүй. Улаанбаатар. 2019
14. Нарантуяа.Т Шинжлэх ухааны судалгааны арга зүй. 2013. УБ. 99, 111, 122, 127х
15. Чимэдсүрэн.О, Хандмаа.С, Мандухай.Г Чанарын судалгаа. Гарын авлага 2015 он УБ. 65х
16. Гэлэгжамц.С, Мөнхжаргал.Д Судалгааны арга зүйг хичээлийн гарын авлага 2016 он УБ. 98, 99, 102, 105, 115х

Study of Traditional Knowledge on *Gentiana* L. plants

Wenchao^{1,4}, Battseren Ts², Batzaya G^{2,3}, Almaz B⁴, Tserentsoo B¹

¹Department of Traditional Prescriptionology, International School of Mongolian Medicine, MNUMS, Ulaanbaatar14210, Mongolia

²Botanical Garden and Research Institute, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar 13330, Mongolia

³University of Mongolian Academy of Science, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar 13330, Mongolia

⁴Key Laboratory of Ethnomedicine of Ministry of Education, Minzu University of China, Beijing 100081, China

E-mail: btd24eE011@gt.mnnums.edu.mn, Tel: +976-99242596

Background: This study presents research on the traditional knowledge regarding Gentian (*Gentiana* L.) plants and their utilization.

Aim: The objective of the study is to explore traditional knowledge about Gentian plants, their medicinal and other uses in various local communities, as well as to identify their vernacular names.

Materials and Methods: The research was conducted in certain regions of Mongolia and the Inner Mongolia Autonomous Region (IMAR), involving 190 cultural heritage bearers through 36 questionnaires. The collected data were analyzed to determine the utilization index and frequency index of Gentian plants, assessing how they are used in the respective regions.

Results: The results indicated the identification of four species of Gentian plants: *Gentiana algida*, *G. macrophylla*, *G. decumbens*, and *Gentianopsis barbata*. The relative frequency indices in Mongolia showed high usage with values of 0.37 for *G. macrophylla*, 0.51 for *G. decumbens*, and 0.55 for *Gentiana algida*. In contrast, the values in IMAR were lower, with 0.08 for white Gentian, 0.18 for large-leaved Gentian, and 0.21 for creeping Gentian. These findings suggest that the utilization of Gentian plants is influenced by intensive livestock farming and agricultural practices in the area.

Conclusion: The use of Gentian plants varies across regions, and the cultural heritage bearers from both countries name them differently based on flower color, size, and local dialects. This study provides valuable information for preserving local traditional knowledge and can be beneficial for researchers and cultural heritage protectors.

Keywords: Ethnobotany, Local nomenclature, White Tash, Blue Degd, Wolf Tongue, Zulgenchimeg